

**Засгийн газраас баталсан “Экологийн цэвэр бүтээгдэхүүн”  
хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ,  
үнэлгээний тайлан**

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл							
1	Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо		Засгийн газрын 2006 оны 3 дугаар сарын 22-ний өдрийн 50 дугаар тогтоол							
2	Хөтөлбөрийн зорилго		“Экологийн цэвэр бүтээгдэхүүн”-ий монгол брэндийг бий болгож гадаад, дотоодын зах зээлд гарган сурталчилж, эдийн засгийн шинэ чадавхийг бүрдүүлэх							
3	Хөтөлбөрийн зорилтууд /Үе шатны хугацаатай нь авч үзэх/	2006-2008 он	1. “Экологийн цэвэр бүтээгдэхүүн” болон түүний үйлдвэрлэлийг дэмжих эрх зүйн тааламжтай орчинг бүрдүүлэх							
		2009-2015 он	2. “Экологийн цэвэр бүтээгдэхүүн” болон түүнийг дэмжих хөтөлбөрийн талаар үйлдвэрлэгч, хэрэглэгчдэд ойлголт, мэдлэг бий болгох 3. Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг салбар бүрээр тодорхойлох, тэргүүлэх чиглэлийг тогтоох, үйлдвэрлэлийг нь дэмжих, ажиллах боловсон хүчнийг бэлтгэх 4. Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дотоод, гадаад худалдааг өргөтгөх, боловсруулалтын сүлжээ-эко маркет бий болгох, экспортын гарцыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх							
4	Зардал /сая төг/	Төсөв	Хөтөлбөрт санхүүжилтийн эх үүсвэрийг заасан хэдий ч зарцуулах хөрөнгийн хэмжээг тогтоогоогүй болно							
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	136.7 сая төг							
		Үүнээс тухайн жилд зарцуулсан	21.7 сая төг							
5	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Дүн	100	90	70	50	30	10	0
		Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын тоо	4					1	1	2
6	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл		Төлөвлөсөн	Гүйцэтгэл				Хувь		
	Шалгуур үзүүлэлт тус бүрээр	1.Баталгаажсан экологийн цэвэр бүтээгдэхүүний нэр төрлийн тоо,	Төлөвлөөгүй	байхгүй				-		
		2.Үйлдвэрлэсэн хэмжээ, тонн	Төлөвлөөгүй	байхгүй				-		
		3. Экологийн цэвэр бүтээгдэ-хүүн үйлдвэрлэгч үйлдвэрийн тооны өсөлт, %-иар	Төлөвлөөгүй	байхгүй				-		
		4.Хөрөнгө оруу-лалтын хэмжээ-ний өсөлт, %-иар	Төлөвлөөгүй	байхгүй				-		
		5.Экспортод гаргасан бүтээгдэ-хүүний нэр төрлийн тоо	Төлөвлөөгүй	байхгүй				-		

		6.Экспортод гаргасан бүтээгдэхүүний хэмжээ, сая төг	Төлөвлөөгүй	байхгүй	-
		7. Гадаад зах зээлийн гарцын тоо	Төлөвлөөгүй	байхгүй	-
		8. Эко-маркет сүлжээний тоо	Төлөвлөөгүй	Бий болоогүй	-
		9.Шинээр бий болсон ажлын байрны тоо	Төлөвлөөгүй	байхгүй	-
7	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа, гарц	Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд экологийн цэвэр бүтээгдэхүүний тодорхойлолт болон холбогдох заалтуудыг тусгасан ба органик хүнсний бүтээгдэхүүний олон улсын 3 стандартыг орчуулсан, үндэсний стандарт болгон батлуулаагүй байна., Хүн ба хүнс сэтгүүлийн тусгай дугаар 300 хувь гаргаж тараасан, “Экологийн цэвэр бүтээгдэхүүн-Монгол брэнд”, “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, “ХАА-н үйлдвэрлэл дэх пестицид, малын эмийн зохистой хэрэглээ, цаашдын хандлага” семинар хийжээ. ”Буудайн үр ариутгал” онол, дадлагын үзүүлэх сургалт, “Монгол Улсад органик буюу экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга зам” хэлэлцүүлэг, “Бэлчээрийн монгол мах” лавлахын эх бэлтгэсэн, 4 аймагт органик мах бэлтгэх боломжийг судалсан зэрэг арга хэмжээг зохион байгуулжээ.			
8	Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг, үр өгөөж/	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын эхний үе шат /2006-2008 он/-нд зарим ажил хийгдсэн боловч экологийн цэвэр бүтээгдэхүүний тодорхойлолт, стандартууд, тийм бүтээгдэхүүнийг баталгаажуулах журам, шалгуур үзүүлэлтүүд зэрэг эхний ээлжинд гарах ёстой хууль эрхзүйн актууд гараагүй байна. Ийм болохоор одоогоор экологийн цэвэр бүтээгдэхүүн гэж албан ёсоор баталгаажуулсан бүтээгдэхүүн алга. Хөтөлбөрийн хэрэгжилт удаан, эхлэлийн төдий байгаа учраас тодорхой үр дүн гарч эхлээгүй байна. Хөтөлбөрийн санхүүжилтэд 2006-2009 онд нийт 136.7 сая төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан ч түүний үр ашиг, үр дүн, өгөөж бодитой хэлэх зүйл гарсангүй. Хөтөлбөрийн хэрэгжилтэд 2007 онд хийсэн үнэлгээнээс хойш зарчмын өөрчлөлт гараагүй. Хөтөлбөр хангалтгүй хэрэгжиж байна.			
9	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал	<ul style="list-style-type: none"> <li>-Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар хөтөлбөрийн удирдлага, тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагууд хангалтгүй ажилласан.</li> <li>-Гүйцэтгэлийн хяналт орхигдсон</li> <li>-Үндэсний хороо журмын дагуу гүйцэтгэх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй.</li> <li>-Экологийн цэвэр бүтээгдэхүүний тухай нэгдсэн ойлголт, тодорхойлолт одоо хир гараагүй байгаа.</li> <li>-Салбар хоорондын энэ талын арга хэмжээний уялдаа, хамтын ажиллагаа хангалтгүй.</li> <li>-Хөтөлбөрийн санхүүжилтийн ихэнхийг хөтөлбөрт холбогдолгүй зүйлд зарцуулдаг.</li> </ul>			

10	Эдгээрээс гарах арга зам	Хөтөлбөрийн хэрэгжүүлж ирсэн 2006-2009 оны үйл ажиллагаанаас үр дүн, өгөөж гараагүй, гарахгүй бодит шалтгаанууд байгаа тул болохоор уг хөтөлбөрийг зогсоож, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, хэрэглээний холбогдох арга хэмжээнүүдийг “Хүнсний баталгаат байдал” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх нь зүйтэй.
11	Хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд холбогдох талуудын оролцоо, хамтын ажиллагаа хангалттай бус, хөтөлбөрийн толгойлох байгууллага-ХХААХҮЯ –нд ачааллыг үүрүүлэх хандлагатай байна. Хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ, БОАЖЯ, МҮХАҮТ-ын ажил уялдаагүй байна.
12	Хөтөлбөрийн талаарх яамны санал / өөрчлөн сайжруулах болон бодлогод үзүүлж буй хөтөлбөрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх талаар гэх мэт/	Засгийн газрын шийдвэр гарган хөтөлбөрийг зогсоох шаардлагатай.Зөвхөн энэ хөтөлбөр төдийгүй бусад хөтөлбөрүүдийн хувьд хамгийн эхэнд хийгдэх ёстой эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн хуулийн актуудыг баталж мөрдүүлэх ажил удаашралтай байдаг. Байгаль орчин ихээр бохирдож байгаа өнөө үед экологийн цэвэр бүтээгдэхүүний талаарх тодорхойлолтыг нягт нарийн гаргах нь чухал байна.
13	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын оролцооны талаархи санал/дэд хөтөлбөртэй байх, тухайн аймаг заавал хэрэгжүүлэх шаардлага байгаа эсэхийг тодорхойлох гэх мэт/	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны агуулгаас харахад нийслэлд төвлөрсөн зарим цөөн арга хэмжээ зохион байгуулаад орон нутагт бараг ажил хийсэнгүй. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 4 жил өнгөрсөн боловч экологийн цэвэр бүтээгдэхүүний тухай нэгдсэн ойлголт, баталгаажуулах журам, стандарт байхгүй тул экологийн цэвэр бүтээгдэхүүн гэж албан ёсоор баталгаажсан нэг ч бүтээгдэхүүн байхгүй. Иймд хөтөлбөрийн үр дүнг өгөгдсөн шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэх боломжгүй байна. Эхний ээлжинд экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой бүс нутгуудыг тогтоох шаардлагатай . Одоогийн байдлаар орон нутгийн төрийн байгууллагуудын оролцоо аймаг орон нутагтаа болон нийслэлд зохиогдсон үзэсгэлэн худалдаанд орон нутгаасаа бүтээгдэхүүнээ оролцуулах ажлыг зохион байгуулах төдийгөөр хязгаарлагдаж байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГ

Т.ГАНТУЛГА